

## ӨНДӨР ГЭГЭНИЙ ГҮН УХААНЫ ҮЗЭЛ САНАА

Г.Лувсанцэрэн /академич/  
Т.Булган /доктор (Ph.D)/  
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

**Түлхүүр уг:** Энх амгалан оришихуй, эв зохицолын ёс зүй-хүч ул хэрэглэх зарчим, эзотерик ба эзотерик хамаарал, холбоо, амгалан хоосны шутэлцээ, “Маани”-ийн утга, монголын буддист сэтгэлээ

**Төвч утга:** Эл өгүүлэлд Өндөр гэгээн Занабазарын гүн ухааны үзлийг түүний гүн ухааны зарим зохиолд тулгуурлан гаргахыг оролдсон болно. Үүнд: Маанийн гүн бүтээлийн арга, Цагийг тохинуулах залбирал зохиолууд нь чухал болно.

Үүнийг өгүүлэхүйн учир шалтгаан:

“Өгүүлэхүйеэ, цаг цөвийн байдалтай, дайн самуун ихтэй байсан XVII зууны тэр үед бага жижиг улс том гүрнийг түшиглэн дагаж тогтоноо аргагүй болсон тухай Халх Монголын төр, шашиныг тэргүүлсэн ноёд, хутагт нарын чуулганаар зөвлөн ярилцахад Орос улсад дагаар орох эсвэл Чин улсад дагаар орох гэсэн хоёр санал гарсныг бид мэднэ. Өндөр гэгээн: Шашин шүтглэг, төрийнх нь хэвийн төлөв хоёрыг харгалзан өөрийн учирлалыг гаргаад Чин улсыг түшиглэх гэсэн саналыг хэлснээр түүгээр тогтсон ажээ. Түүх сударт тэмдэглэснийг үзвээс ноёдын саналд “дагаар орох” гэсэн үгийг хэрэглэсэн байхад Хутагтын намтарт “түшиглэх” (iten) гэсэн үгийг хэрэглэсэн нь учиртай буй за. 1691 онд Долнуурт Чин улсын хаан Кан-шитай хийсэн хэлэлцээрээр Халх Монгол Манж-хятадын гүрний эзэн эрхийг хүлээж төрийн бие даасан бүрэн эрхэт байдлаа алдсан нь үнэн. Нөгөө талаар энэ хэлэлцээр түүхийн агуулгаараа

их үндэстний уусгах нөлөөний эсрэг хоёр бага үндэстний хийсэн зөвшил тохиролцоо болсон байна хэмээн үзэх бүрэн үндэстэй юм. Учир юун хэмээвээс, энэ тохиролцооны үрээр Монгол орныг бусдын гар нөлөө хүргэлгүй, хэрэг дээрээ уусгах аюулаас хамгаалан нэгэн маягаар битүүмжлэн хадгалсан ажээ. Монгол орон хоёр зуу гаруй жил хэдийгээр түгжигдмэл, өөрчлөлт хөгжилгүй байлаа ч тусгаар тогтолцын суурь болж чадах үндэстний өвөрмөц онцлог, төрх байдлаа хөндөлгүй хадгалж чадсан юм... (318-324х)

**Энх амгалан оришихуйн үзэл санаа:** Монголын буддизмд энх амгалангийн үзлээ юуны өмнө буддын дөрвөн цаглашгүйд тулгуурлана. Энэ нь та бүхний сайн мэдэх асрахуй, нигүүлсэхүй, тэгш, баясталан дөрөв болно. Монгол ном сударт дөрвөн цаглашгүйг тодорхойлохдоо:

- их асрахуй нь хамаг амьтныг нийтээр өршөөн аварч тус хийх

- их нигүүлсэхүй нь хамаг амьтныг нийтээр энэрэн асарч зовлонгоос гэтэлгэх
- их тэгш нь хамаг амьтныг ялгалгүй нэгэн адил асарч үзэх
- их баясгалан нь хамаг амьтныг баясахуй бээр тус хийж, бусдын хор хөнөөлд гаслах, хорсох сэтгэлгүй бөгөөд ямагт баясгалангаар асран нигүүлсэх мөн гэсэн байдал.

Монголын буддизмд бие, хэл, сэтгэлийн ариун ёсыг баримтлахыг эрхэмлэж энх амгалан, эв зохицолтой, шударгаар аж төрөхийн ёс суртахууны зарчмыг тодорхойлон мөрдлөг болгодог.

Бие хүний ёс суртахууны төгөлдөржилд таван хорын үндсийг таслан Би болон минийх хэмээн баримтлах аминч үзлийг хаахыг эн тэргүүнээ эрхэмлэдэг. Тэрхүү таван хор нь тачаангүй, урин, мунхаг, омог, найдангүй тав бөгөөд ном сударт тэдгээрийг тодорхойлоходоо:

- тачаангүй гэгч хүсэл, сайхан өнгө, эд агуурс, мал хөрөнгө зэрэгт хүсэх дурлахын нэр
- урин гэгчид бусдад уурлах, хилэгнэх тэргүүтэн багтах
- мунхаг гэгч сурч үл мэдэх, эргүүгийн нэр
- омог гэгч санаа дэний өндөр хөөрүүдэн дордсыг дарлан өөрийн илүүг хөөргөх, олонд дээрэнгүйлэхийн нэр
- найдангүй гэдэг хөнгөн дөлгөөн, өчүүхэн төдий хичээхгүй, дэний дураар балмаглан хөвхөлзөж, үг хэл, явдал, үзэл дээр дээд доод, хөгшин залууг үл ялгахыг хэлнэ гэсэн байна.

Эл таван хорыг монголын сэтгэгчид дурслэн бичихдээ “Тачаангүй нь усан мэт давлан, урин нь гал мэт бадран, мунхаг нь харанхуй мэт бүрхэн, омог нь уул мэт бөгөөд найдангүй нь хий мэт дэгдрэн, Би хэмээн баримтлах нь төмөр чөдөрт батад хүлэгдсэн мэт” болно гээд таван хорыг таслан хааснаар Би хэмээн нотод баримтлахын хүлээс алдарч зовлонгоос ангижарна гэж үзэж байв. Тэгэхдээ Би-гийн тухай үзэл нь буддын философи дахь юмын Би болон бодгалийн Би-гийн тухай гүн нарийн сургаалд тулгуурлаж байдал билээ.

Би хэмээн баримтлах үзэлд автагдан таван хорыг бие, хэл, сэтгэлээр үйлдэх нь энх амгалангийн ёс суртахуунд харш гээд түүнийг тодорхойлох, түүнээс ангижрахад зориулсан монголын буддизмын ойлголт нь арван хар нүгэл, арван цагаан буян бөгөөд эдгээр ойлголт нийтэд түгээмэл дэлгэрсэн билээ.

Энэ арван хар нүглийг “Тонилохуйн чимэг” зохиолд тодорхойлж тайлбарласнаар үзвэл: Арван хар нүгэл нь аль хэмээвээс биеийн үүднээс амин нядлах, эс өгснийг авах, хурьцахуй бээр алжаас явах гурван буй; хэлний үүднээс худал өгүүлэх, олхио үг, ширүүн үг, тохуу үг дөрвөн; сэтгэлийн үүднээс харам сэтгэл, хорт сэтгэл, буруу үзэл гурван; эднийг арван хар нүгэл хэмээюу гэсэн байдал. Ийнхүү бие хэл, сэтгэл гурваар хүн төрөлхтөний эерэг сайн ёс суртахуунд харшлах үйлдэл хийхийг нүгэл гэж үзэн цээрлэж байв.

“Тонилохуйн чимэг” зохиолд дурдсанаар бие, хэл, сэтгэлийн тэр арван цагаан буян нь: Бусдын амийг

аврахуй, агуу их өглөг өгөхүй, ариун явдлаар явахуй, үнэн зөв шударга үгсийг өгүүлэхүй, өшөөтнийг найруулахуй, магад амирлангуй шударга өгүүлэхүй, туст гавьяат үг өгүүлэхүй, тачаангуй өчүүхэн болоод булилан мэдэхүй, асралуй өршөөхүйг бясалгахуй, үнэн магад утгад оролдохуй энэ арав болно.

Үүнээс хамаг бүгдийг энэрэн асарч, бусдын зовлонгийн төлөө зовж, өөр болон бусдыг зовлонгоос гэтэлгэн аз жаргал авчрах; үнэн шударга, ариун аж төрөх ёсыг мөрдөн дагах; аливаа хор, нүглийг боон дарж, буяныг даган арвижуулах; энэ үндсэн дээр хүмүүсийн хоорондын эв нөхөрсөг; зохилдонгуй харилцааг тогтоон бататгах буддын ёс суртахууны эерэг энэрэнгүй зарчмууд гарч ирж байгаа юм. Үүнд бусдыг зовоож жаргалыг олох бус, харин ч бусдыг зовлонгоос гэтэлгэж жаргал олгосноор амирлах тухай буддизмын сургаалыг монголын буддизмд онцгойлон үздэг байсныг өнөөгийн нөхцөлтэй холбогдуулан цохон тэмдэглэмээр байна. Түvd, Монголын буддизмд хоёр дахь Будда мэтээр хүндэлдэг Жово Адиша шүлэглэхдээ:

“Бусдын зовлонг арилгахын тулд  
Буянтай үйлийг бүтээдэг  
Бусдын жаргалыг эвдэхийн тулд  
Бузар хар нүглийг хийдэг  
Бусдын зовлонг арилгахын тулд  
зововч  
Буцаад бүгдэд жаргал ирдэг  
Бусдын жаргалыг эвдэн жаргавч  
Буцаад бүгдэд зовлон авчирдаг” гэсэн

асарч энэрэхийн гүн утга өнөө үед бүр ч тулгам чухал сонсогдож байна.

**Эв нэгдлийн үзэл санаа:** Монголын буддизмд эв нэгдлийн үзэл санааг ихэд өргөмжилдэг. Энэ нь буддын сургаалаас гүн үндэстэй юм.

Говийн ноёнхутагт гэж алдаршсан XIX зууны эхэн үеийн Монголын яруу найрагч, сэтгэгч Д.Данзанравжаа хүн ард, улс түмний эв нэгдэл, найрамал нөхөрлөлийг эрхэмлэн дуулж шүлэглэхдээ:

“Монголчууд ихэд ч эв хэрэгтэй  
Багад ч эв хэрэгтэй гэдэг  
Эвгүй бол эх, хөвүүн хоёр ч бол дайсан  
Эвтэй бол энгийн хар элэгт хүн ч бол садан

Элдэв жаргал зовлонд өнчрөхгүй гэгч эвийн эрдэм” хэмээн онцлон тэмдэглэж байв. Эв найрамдлын хүрээ хэмжээ, ач тусыг үзүүлж монголын буддист энэ сэтгэгч хэлэхдээ:

“...Хоёр хаан эвтэй болбол  
Дайчин улс амгалан болно  
Эвгүй хоёр хааныг дайтаж байхад  
Эвтэй өвгөн, эмгэн хоёр  
Амраглан сууцгаана  
Эвтэй хоёр хааны гүрэн амгалан  
байхад  
Эвгүй залуу сайхан хүү, хүүхэн хоёр ч  
Нэг нэгнээ алалцах гэж ч байна  
Эвтэй өвгөн, эмгэн хоёр ч  
Эвийн хүчинд жаргасан буй за  
Эвгүй хоёр хаан хүсэл, эрдэм  
Юугаар дутаад зовсон учрыг бод  
Жигүүр дутаад звсон учрыг бод  
Эв хэрэггүй хүн нэг ч үгүй” гэжээ.

Тэгээд:

“Заан, сармагчин, туулай, шувуу

дөрвүүл

Эвтэй болоод сонин үлгэр болсоныг

Үз

Ганцхан цаст уулын цагаан арслан

Хар шогоолжинд баригдсаныг үз” гэж эвийн хүчийг эрт урьдын үлгэр домогтой зүйрлэн харуулж байв. Эдгээр сургаал, номлолын утга эдүгээ ч ач холбогдоо огт алдаагүй байгаа нь ойлгомжтой.

**Өндөр гэгээний бодол бясалгал:**

“Маанийн гүн бүтээлийн арга” зохиолд юуны өмнө маани-бадмын ёс бүээлийг хүлээн авах бодгалийн бэлгэ чанар, тэр бээр юуг анхаарч авах учиртайг өгүүлсэн байна. Аливаа бодгальд буй бурханы зүрхэн буюу бурхан чанарыг хэрхэн өдөөж, түүнд хэрхэн хургэхийг өргөн тавьж үүнд чин итгэл сүсэг, үнэнхүү магад гарахын чармайлт нэн эрхэм гэж гэгээнтэн үзжээ. Анхааран авахын хувьд энэрэнгүй сэтгэл, амгалан оршихуйг заан өгүүлж түүнийг алагчлал үгүй нигүүлсэн энэрэгч Авалокитешвара (Жанрайсиг)-гийн бүтээлээр илэрхийлж, “Нэгдүгээр үзэгч эрхтэн (Жанрайсиг-Г.Л) . . . огторгуй дүүрэн оршисоныг бас бас сүслэхүүгээртодруулан уйлд” гэжээ. Энэ нь дотоод сэтгэлийн хүчээ чин сүслэхүүгээр дайчлан гаргаж түгээмэл нигүүлсэнгүй, амарлингүйн ухааралд хүрч болохыг заасан хэрэг гэж үзэж байна. Эл бүхнийг Очирт хөлгөний бүтээлийн аргаар дурдан илэрхийлсэн нь утга нэн нарийн, гүнзгий ажгуу.

**Тарнийг бүтээхүй:** Зохиолын гол утга нь Очирт буюу тарнийн хөлгөний

үүсгэлийн зэрэг (bskyed rim), төгсгөлийн зэрэг (rdzogs rim) хоёрын нарийн утгыг хураан илэрхийлж адистидлан зарлигласанд оршино. Тэрхүү зэргийн агуулга нь сэтгэлийн аймаг, төвийн аймаг, увидасын аймаг гэсэн гурван бурдлээс тодог байна. Юуны өмнө янагуухийн аливаа үзэгдлийг сэтгэлд барьж уг оногдохуун (вишай)-аас сэтгэлийг цэврээр ялан авахад өөрөө болон бэлгэ билиг ургана. Энэ нь дүрс, хувилгаан биеэс хоосонд орох цэвэр ухаарал болох ажээ. Дараагийн шатанд түүнээс дээшлэн зорилгоос хагацсан, үйлдвэр, хичээл үгүйн агаарт агуулсан, үүгээрээ дүрс, солонгын биеийг очирын биед бүтээх гүн аргад орсон дээд оюуны бясалгалаар бэлгэ билгүүний биед орохуй нь төвийн аймаг болно. Түүнээ жинхэнэ хүрэн дадахуйд аливаа ялгарал, авах гээхээс хагацан, хослон орох хоёр үгүй болж (эсрэг тэсрэг чанараас дээш гарч), ийм бэлгэ билгээр орчлон нирваан хоёрын ялгаа ч үгүй болж номын дээд чанар, хоосон чанарын агаараа хүрэх ажгуу. Энэ нь увидасын аймаг бөгөөд үүгээр шид бүтээлийн оньс тайлгадах ажээ. Ийнхүү жирийн ухааныг сарниулан хир үгүй, тодорхой чанар үгүй хоосонд хүргэж жинхэнэ цэврээр ухаан хоосныг илэрхийлэх нь төгсгөлийн зэрэг болох юм. Түүнд гүн бясалгалаар хүрнэ.

Ийм төвшинд хүрэхэд ахуй ёсны аливаа суурь, ялгаа үгүй, мөн чанар угаас арилсан, хоосон чанар өөсвөөн бүтсэн, нигүүлсэхүй хотол түгээмэл болсон ажгуу. Өөрөөр хэлбэл бурханы бүтээл, бурханлаг чанарын бүтээл болох ажээ.

**Маанийн утгаас нээхүй:** Маанийн бүтээл зохиолыг “Зургаан үсгийн бүтээл”

гэж нэрлэх нь ч буй. “Ом ма ни бад мэ хум” гэсэн тарни бол Очирт хөлгөний хамаг гүн нарийн утгыг хураан илэрхийлсэн хэллэг юм. Мани гэдэг чандмана эрдэнэ, бадма гэдэг лянхуа цэцэг, Занабазар гэгээнтэн тус зохиолдоо хамаг бүхнийг маани, бадма хоёрт хурааж, түүний бүтээлээр аливаа бүхний язгуурын шүтэлцээ, ертөнцийн бүхий л жам тогтолцоог илэрхийлсэн байна.

Маанийг арга, их амгалан хэмээн үзэж бадмыг билиг, их хоосон (хоосон чанар) хэмээн илэрхийлэн түүгээр бодгалийн болон ном (ертөнц)-ын уг язгуурын чанарыг шүтэлцүүлэн гаргажээ. Хоосон чанар бол янагуухийн алимад юмын уг чанадад байх язгуур үндэс нь мөн бөгөөд ямарваа тодорхой шинж, бэлгээр ул илэрхийлэгдэнэ.

Бодгалийн утг байгаа бурханлаг чанарыг хоосон чанартай шүтэлцүүлэн Занабазар гэгээнтэн илэрхийлэхдээ: “*Маани хэмээх чандмана буюу. Тэр ч ул урвах үнэмлэхүй их амгалан огторгуй түгээмэл бөгөөд мөнхүү бурхан чанар болой. Түүний орших орон хоосны шутээн, номын чанарын хуурцагт орисон тэрхүү чанар бөгөөд бадма дор болой*” гэжээ.

Ийнхүү мааниар илэрхийлж буй их амгалан нь түгээмэл, үнэмлэхүй чанар, үүгээрээ хоосон чанарт шүтэн суурилах бөгөөд энэ нь чухам бурханлаг чанар, бурхан юм гэж айлдсан байна. Тэр хаана буй хэмээвээс, хоосон чанарын шүтээн (*stong gzhi*)-д, номын чанарт бий, бадмад бий гэсэн нь их амгалан, хоосон чанарын шүтэлцээ маани-бадмын шүтэн барилдлагыг илэрхийлсэн хэрэг. Хоосны шүтээн (*stong gzhi*) гэдэг ойлголтын

тухайд бол энэ нь ерөөс хоосон чанар гэдэг бүхнээс гадуур байх, бодит суурь угүй, эзэнгүй хийсвэр явах зүйл биш, харин шүтэх оронтой, өөрөөр хэлбэл дүрст лагшин буюу янагуухид, нэрийтгэлийн юмст суурилдаг, тэр бүгдийн угийн язгуур чанар юм гэсэн санаа болно.

Хоосон чанар нь бидний урьд дурдсанчилан янагуухийн юмын мөн чанар, үндсийг хөөн ухаарсаар юмс, үзэгдлийн аливаа тодорхой шинж, харилцаанаас хийсвэрлэн дээш гарч, тэгсэнээрээ ертөнцийн дотоод руу улам гунзгийрч, мунхагийг даван туулж, ертөнцийн уг язгуурыг нь үнэнээр онон барьж буй хэрэг юм. Их амгалан бол бодгалийн сэтгэлийн аливаа хир нисваанисыг хаан боож, сэтгэлийн угийн ариун чанарыг таньж, гүн бясалгалын хүчээр түүнд ойртон дөхсөөр урин, тачаангуйг даван гарч, билгийн чанад хязгаараа хүрч буй ариусал юм. Ийнхүү их хоосон амгалан хоёр нь ном (юмс)-ын болон бодгал (сэтгэл)-ийн би-г давж, номын болон бодгалийн нарийн би-үгүйд хүрэхүй болох бөгөөд тэр цэгт очиж нийлнэ.

#### **Би угүй хэмээх үзлийн тухайд:**

....Энэ ялдамд би-үгүйн тухай товч дурдахад: Өөрийн сэтгэлийг огоот номхотгож, өөрийн би-г даван гарах өөрөөр хэлбэл, юмын болон бодгалийн би хэмээх эзэн чанар үнэхээр бүтээгүй, тэр нь нэрийтгэлийн төдийд яригдаж байгаа гэдгийг жинхэнээр ухаарч чадсан цагт би-г давж, би угүй болно. Би, минийх гэсэн үзэл баримтлааас ангижирч байж сая тонилон гэгээрнэ. Би-д баримтлах болон би-үгүйн тухай асуудлыг буддын

философиийн чиглэлүүдэд харилцан ялгаатайгаар тайлбарладаг.

**Төв узэл:** Түүний дотроос мадхьямака прасангика (түвшээр: вум танжурвын ёс гэнэ) буюу хэтрүүлэгч төв үзлийн баримтлал тун өвөрмөц юм. Монголын эрдэмтэн мэргэд түүний дотор Өндөр гэгээн Занабазарын гол үзэл арга зүйгээ болгон баримталдаг эл хэтрүүлэгч төв үзлийн ёсоор бол: Бодгаль бол мөн чанараар бүтсэнээс хоосныг бодгалийн би үгүй нарийн (микро би үгүй) гэх ба юмс нэрийтгэлд ч үнэнээр бүтсэн бус гээд нэрийтгэлийн суурь, түүнийг баримталсан шалгадаг ухаан хоёул үнэнээс хоосныг номын нарийн би үгүй гэдэг. Өөрөөр хэлбэл, юмсыг бид томъёо нэрийтгэлийн төдий үнэн гэж баримтлах нь ч басхүү үнэхээрин бус, хоосон чанартай юм. Энэхүү бодгалийн би үгүй нарийн, номын би үгүй нарийн хоёр нь хоосон чанарын суурийн үүднээс л ялгаатай өөрөөр хэлбэл, нэг нь бодгалийг үнэхээр бүтсэн бус хэмээн хаасан, нөгөө нь дурс тэргүүтэн аливаа юмс үнэхээр бүтсэн бус хэмээн хаасан, чухам үүгээрээ ялгагдахаас бус хаагдахууны үүднээс бол ялгааүй юм. Чингэхлээр бодгалийн би үгүй нарийн, номын би үгүй нарийн хоёрт нарийн бүдүүний ялгал үгүй бөгөөд түүнийг ахуй ёсны туйл юм гэж хэтрүүлэх төв үзлийн ёсонд үзнэ. Энэ тухай бид арай дэлгэрэнгүй авч үзсэн билээ. Тэр цэгт нэг талаас ертөнцийн язгуурыг танин мэдсэн ухаарал хоосон чанарт тулж, нөгөө талаас бодгалийн сэтгэлээ ариусгах нь билгийн чанад хязгаараа тулж, их амарлингуйд хүрэх энэ хоёр нь нэг цэг дээр очиж нийлнэ.

**Өндөр гэгээний болгоол:** Тэр туйлын цэгт хоосон чанар амгалан оршихуй хоёр нийлэн нэгддэгийг илэрхийлж Занабазар гэгээнтэн бичихдээ: “*Эс арилсан тийн мэдэх хоосны болсон оронд арилсан түүнчлэн чанарын агаараа арга билиг хоёр үгүй гэгээн гэрлийн амгалан хоосон хослон орсон маани бадмын магал утга*” гэжээ.

**Амгалан хоосны шүтэлцээ:** ..Энд олон гүн санаа хураасан байна. “*Эс арилсан тийн мэдэх хоосны орон болсон*” гэдэг нь арилсан ариун чанарт хүрээгүй байгаа ертөнцийн янагхуухийн юмсыг тийн мэдэхүйгээр таньсан оюуны нүүрт хоосон чанар оногдохуун (объект) болно гэсэн утга. Энэ нь цаагуураа хоосны суурь, доншийн санааг давхар илэрхийлж байна. Түүнийг танин барьсан нь түүнчлэн чанар (*tafhata*) болох юм. Түүнд түшиглэн гарч ирсэн арилсан үнэмлэхүй чанарт хүрэхээр их амгалан хоосон чанар хоёр хослон нэгдэж гэгээрэхүй болох бөгөөд чингэхэд аливаа тодорхой шинж, ялгавар арилж арга билгийн ялгаа ч үгүй болно өөрөөр хэлбэл, их хоосон их амгалан хоёр адилсана гэсэн утга юм хэмээн үзэж байна. Чухам үүнийг “маани бадмын магад утга” гэсэн байна.

Энэ нь чухамдаа бурхан, бурхан чанар болно. Маанийн бүтээл гэдэг бурханы бүтээл юм. Иймд Жанрайсиг бурханы бүтээл гэдэг чухамхүү тарнийн ёсны аргаар нарийвчлан илэрхийлсэн их нигүүлсэхүй, их амгалангийн бүтээл болох бөгөөд түүгээр ертөнцийн уг язгуурыг Их Гэгээнтний чадал, бясалгалаар илэрхийлж түүнд олны сүсэг, сэтгэлийг нэгтгэн дагуулж, түүндээ ард олон орон гүрнээ адистидлан шингээсэн хэрэг ажээ. /91-96x/

## ДҮГНЭЛТ

1. Бие хүний дотоод сэтгэлийг ариусган биеийн хүчийг сэтгэл, оюуны хүчинд захируулахыг монголын буддизмд энхийн чухал зарчим болгодог. Эд агуурсын баялгийг асар их арвигасан хэрнээ оюун санааны баялгийг арвигаж, сэтгэлийг төгөлдөржүүлэхгүй аваас хүн төрөлхтөн сүйрэлд хүрч болзошгүй юм. Эдүгээ улс түмний хоорондын энх тайван, эв зохицлыг бэхжүүлэхэд оюун санааны баялаг, соёлын үнэт зүйлсийн роль үлэмж нэмэгдэж байна.

2. Нийт буддизмын нэгэн адилаар монголын буддизмд өөр бусдыг энэрэн үзэж, бусдын зовлонгийн төлөө зовж, түүнийг өөрөө арилган бусадад тус үзүүлэх, бусдын жаргал лугаа төгссөнийг үзээд өөрт үлэмж баясал төрөх, ингэж Би-гийн хүлээсийг огоорон, аминч явцуу үзлийг боон дарах асрахуй энэрэхүйн зарчим нь энх амгалан, эв найрамдалын нэг үндсэн зарчим болно. Ийнхүү бусдын зовлонгоор жаргал хийх бус, харин бусадад жаргал эдлүүлсэнээрээ өөрөө амгалан байх ёс нь одоогийн улс хоорондын шинэ харилцаа, шинэ сэтгэхүйн зарчимд нийлэлцэнэ гэж үзэж байна.

Эцэст нь хэлэхэд, Өндөр гэгээн Занабазарын нийгмийн үзэл, тухайн үеийн тулгамдсан асуудлын шийдлийн онолын үндэс нь чухамхүү эл маани-бадмын бүтээл болжээ хэмээн үзэж болно гэж бодож байна.

3. Монголын буддизмд ер нь хамаг хор, хамаг нүгэл хилэнцийн үндэс нь хүсэл, шунал хэтэрсэнээс, ханалыг үл мэдэхээс гарна гэж үздэг нь хүн төрөлхтөнд

аюул заналыг учруулдаг дайны үүсвэр шалтгааныг илчлэн хориглоход чухал ач холбогдолтой, энхийг хамгаалахын нэг зарчим юм. Эдүгээгийн дайны хар аюул, үй олноор устгах зэвсгээр хөөцөлдөж буй үед эл үндэслэлийн үнэн зөв нь улам тод болж байна.

4. Энх амгалан тогтоон хангахад эвийн хүч, зохицол, найрамдал эн тэргүүнд хэрэгтэй болохыг буддистууд, түүний дотор монголын буддистууд ямагт онцлон тэмдэглэж, түүний төлөө мөргөл, үйлсээ зориулж ирсэн түүхтэйг бид дурдсан. Эдүгээ үед энэ зарчмын утга холбогдол үлэмж өсөж байна. Эдүгээ бид буддын шашны энх амгалан, эв зохицлын их хүчийг нэг үндэстэнээс нөгөөг колончилон барихад эвлэрэлийн зэвсэг болгох биш харин олон ус үндэстэнүүдийн өөр хоорондын эв зохицол, хамтын нөхөрсөг харьцааг бататган хөгжүүлэхэд чиглүүлэх ёстой. Ийм боломжийн аятай үе ч бий болоод байна. Үүнд орон бүрийн буддистуудын хамтын чармайлт чухал байгаа юм. Энэ нь энх тунх, аз жаргалтай аж төрөх гэсэн нийт хүн ардын эрх ашигт ч, хүмүүст ч ийм аз жаргал олгож, нийтэд туслахын төлөө байдаг буддын шашин, буддистуудын ариун ёсонд ч бүрэн нийцэж байгаа юм.

## **НОМ ЗҮЙ**

1. Занабазар. Цагийг тохинуулах залбирал
2. Занабазар. Маанийн гүн бүтээл
3. Ш. Бира. Өндөр гэгээн Занабазар: Цаг лугаа зохицуулсан залбирал-Адстээдийн дээдийг хайрлагч оршвой. УБ., 1995
4. Г.Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол түүхийн асуудлаас, УБ., 2010

## **ABSTRACT**

Academic G.Lubsantseren (1935-2008) was one of the Mongolian prominent buddhalogy scholars of XX century who made great works of scientific research in the field of Buddhist philosophy and thoughts in India, Tibet, Mongolia.

Among his research works, studies on the middle view of Buddhist philosophy and Nagarjunas' Philosophy in particular, have occurred main places. In last year 2015, his family and scholars, as well as he scientific conference organized by the Academy of science and National University of Mongolia celebrated the 80th anniversary of academic G.Lubsantseren. And many presentations and papers by modern scientists offered there.

In this light, we would like to offer some sketches and glimpses from his articles and studies works focusing on nirvana idea, peace of existence, unity of mind and emptiness, non- violence principle, esoteric comment on the mantra, and ethics on peace and harmony codes based on Mongolian Buddhist thought etc., including the works by Mongolian Buddhist thinkers, especially Zanabazar (1635-1723) who was the first Bogd Jebzundamba gegeen, Spiritual leader of Mongolia at the XVII century.